

Гарчиг

1. БҮЛЭГ-1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
1.Төслийн товч мэдээлэл	3
1. Төслийн талбайн байршил, нэр:.....	3
2.Ордын физик газарзүйн онцлог, дэд бүтэц	6
1. Физик газарзүй, геоморфологи	6
2. Уур амьсгал	7
3. Ус зүй.....	7
4. Ургамал, амьтан	7
5. Хүн ам, дэд бүтэц.....	8
6. Геологийн судалгааны түүх.....	8
3.Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажлын горим	9
4.Ашиглалтын систем	10
5.Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	11
1. Нүүрсний хаягдал, бохирдлын тооцоо	11
2. Уулын ажлын төлөвлөгөө, уурхайн талбайг ашиглах дараалал	13
3. 2023 оны уулын ажлын хөрс хуулалт болон нүүрс олборлолтын хэмжээ.....	14
4. Ухаж ачих ажил.....	15
5. Уурхайн тээвэр.....	16
6. Овоолгын аж ахуй	18
6.Дэд бүтэц	20
1. Усны хэрэглээ.....	20
2. Цахилгааны хэрэглээ.....	21
2. БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	22

1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

22

2.Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	22
3.Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл	26
3. БҮЛЭГ-3. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	29
3.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	30
4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	32
5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	32
6.Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	32
7.Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	34
8.Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	35
9.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	37
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	38
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ.....	39

1. БҮЛЭГ-1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Төслийн товч мэдээлэл

1. Төслийн талбайн байршил, нэр:

- Талбайн байршил - Дундговь аймгийн Баянжаргалан сум
- Талбайн нэр - Хөөтийн хонхор-2
- Талбайн хэмжээ - 1046.73 га
- Планшетын дугаар - L48-84 хавтгай

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгийн координатууд

Тусгай зөвшөөрлийн дугаар	Цэгийн дугаар	Өрөгрөг	Уртраг	Талбайн хэмжээ, га
MV-020772	1	107° 43' 1.55"	45° 45' 1.6"	1046.73 га
	2	107° 41' 31.54"	45° 45' 1.6"	
	3	107° 41' 31.54"	45° 42' 49.47"	
	4	107° 41' 44.85"	45° 42' 49.47"	
	5	107° 41' 44.85"	45° 42' 35.8"	
	6	107° 41' 31.54"	45° 42' 35.8"	
	7	107° 41' 31.54"	45° 42' 8.61"	
	8	107° 42' 20.54"	45° 42' 8.61"	
	9	107° 42' 20.54"	45° 42' 1.6"	
	10	107° 43' 1.53"	45° 42' 1.6"	



Зураг 1. Хөөтийн хонхор – 2 нүүрсний ордын байршлын зураг

Биг Могул коул энд энерги ХХК өөрийн хөрөнгөөр 2010-2013 онуудад гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлаар Хөөтийн хонхор-2 талбайд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хайгуулын ажлаар нүүрсний ордын геологийн тогтоц, өөрчлөлтийн зүй тогтол, техник хагарал эвдрэл, нүүрсний давхраасын бүтэц болон чанарын өөрчлөлтийн зүй тогтоц бүрэн судлагдсан.

Мөн ордын хэмжээнд гидрогеологи, инженер геологийн нөхцлийг судалж, ордын уул техникийн нөхцлийг тогтоосон ба уул техникийн таатай нөхцөлтэй гэж үзлээ.

АМХЭГ-аас 1998 онд гаргасан Ашигт малтмалын нөөц, баялагийн ангилалын түр зааврыг баримтлан Хөөтийн хонхор-2 нүүрсний ордын 1090 м үнэмлэхүй түвшин хүртэл буюу газрын гадаргуугаас 100-110 м хүртэлх гүнд нөөцийг бодиттой В зэргээр - 7189.31 мян.тн, боломжтой С зэргээр 11001.90 мян.тн, нийт В+С нөөц 18191.21 мян.тн

тооцоолов. Үүнээс ил уурхайн хил дотор $B+C=15312.29$ мян.тн нүүрсний нөөцийг
тогтоосон.

Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг



Хөөтийн хонхор-2 чулуун нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км, Чойроос баруун урагш 100 км, Мандалговь хотоос зүүн урагш 130 км, Баянжаргалан сумаас 25 км-т оршино. Улаанбаатар-Замын Үүдийн төмөр зам, авто машины хатуу хучилттай замаас 90 км, өндөр хүчдэлийн шугамаас 45 км зайтай оршдог. Тусгай зөвшөөрлийн талбай нь манай улсын дэд бүтэц сайтай дүүрэгт оршино.

2. Ордын физик газарзүйн онцлог, дэд бүтэц

1. Физик газарзүй, геоморфологи

Төслийн талбай нь Төв Монголын өмнөд хэсэгт хамаарагдах ба гадаргуу нь жижиг толгод хотгор гүдгэртэй тэгш тал газар болно. Хар тэвшийн тусгай зөвшөөрлийн талбай байрших Хөөтийн нүүрс-шатах занарын орд газар нь Монгол орны хээр талын бүс нутагт байршина. Засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Баянжаргалан суманд харьяалагдах ба геоморфологийн хувьд жижиг толгод, ухаа гүвээ, хотгор, гүдгэрийн хэв шинжийг хадгалсан. Орд хойд, баруун хойд талаараа намхан уулархаг толгод зонхилох бөгөөд өгөршилд бага орсон бялхмал чулуулагуудтай. Өмнөд, баруун өмнөд хэсгээрээ жижиг хагарлаар үүссэн, бага зэрэг өргөгдсөн дэл, толгодуудыг нийтэд нь авч үзвэл

синклиналь, брахисинклиналь хэлбэрийн бүтцийг үүсгэсэн байна. Энэ хотгорт байгаа хамгийн өндөр цэг нь далайн түвшингээс 1258,2м өндөр орой бүхий Хар тэвш уул.

2. Уур амьсгал

Цаг уурын хувьд Төв Монголын эрс, тэс уур амьсгалтай нутагт байрлах ба өвлийн улиралд дунджаар -16° - -31°C хэмийн хүйтэн, зуны улиралд дунджаар $+20^{\circ}$ - 25°C хэмийн халуун байдаг. Жилд унах хур тунадасны дундаж хэмжээ 205-350 мм, хавар, намрын улиралд хүчтэй салхи элбэг гарах ба хүч нь 15-20м/сек хүрнэ. Салхины чиглэл нь баруун, баруун хойт зүгээс зонхилон салхилна.

Энгэр-ус, Хавиргын худгууд хайгуулын талбайгаас 1-8 км зайтай байдаг. Шатдаг занар, нүүрс, нефть агуулсан хурдсанд агуулагддаг ус эрдэжилт ихтэй байдаг учир ундны усны шаардлага хангадаггүй эрдэжилт ихтэй байдаг..

Энэ бүс нутагт хүн ам сийрэг суурьшин дан ганц мал аж ахуй эрхэлдэг. Улаанбаатар – Замын- Үүдийн төмөр зам, авто машины хатуу хучилттай замаас 90км , өндөр хүчдлийн шугамаас 45 км зайтай оршдог. Тусгай зөвшөөрлийн талбай нь манай улсын дэд бүтэц сайтай дүүрэгт оршдог.

3. Ус зүй

Судалгаагаар газар дорхи усны статистик түвшин 5.8м, динамик түвшин 9.0м , газар дорхи усны ундарга 0.5 л/сек болохыг тогтоосон байна. Хөөтийн ордын орчимд тархсан газар доорхи усны химийн найрлага нь хлор сульфатын ангийн, натри-калийн бүлгийн ус зонхилох бөгөөд усны эрдэжилтийн хэмжээ 3.1-3.5г/л, ерөнхий хатуулаг 52.7-57.62мг-экв, рН 15.6-16.9 мг-эка байна.Шинжилгээний дүнгээс үзэхэд эрдэжилт ихтэй давслаг, хатуулаг их илэрч байгаа нь бетонон эдлэлд тохиромж муутай, унд ахуйн хэрэгцээнд тохирохгүй.

4. Ургамал, амьтан

Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвст, монгол өвс-хазаар өвст говирхог хээр боловч монгол өвст-таанат, монгол өвст-бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг.

Амьтны хувьд туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр бөгөөд намартаа нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс сар, элээ, хэрээ, тогоруу, ногтруу, шаазгай, хэвлээр явагчидаас могой, гүрвэл, мэрэгчдээс шар сүүлт, алаг даага, тарвага (маш бага), махчин амьтдаас үнэг, хярс зэрэг тохиолдоно.

5. Хүн ам, дэд бүтэц

Улаанбаатар хотоос зүүн урагш 300км, төмөр замын зангилаа Чойр хотоос баруун урагш 110км, аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 130км, Налайх-Замын-Үүдийн хатуу хучилттай авто замаас 110км өнгөрнө. Ашиглалтын талбайд хүн ам байнга суурьших төв газар байхгүй. Хар тэвшийн нүүрсний уурхай нь Дундговь аймгийн Говь-Угтаал, Өндөршил, Гурван сайхан, Цагаан дэлгэр, Дэрэн, Дэлгэр цогт зэрэг сумдын хүн ам олноор суурьшсан газар Баянжаргалангаас 25км зайд оршино.

6. Геологийн судалгааны түүх

Энэ дүүргийн геологийн судалгааны ажил нь 1950-аад оноос эхлэлтэй боловч региональ хэлбэрээс төдийлөн хэтэрч чадаагүй байна. 1952-1953 онд Монгол-нефть трестийн харьяанд геологч В.И.Браташ 1:200000 масштабын геологийн зураглал болон эрлийн маршрутын ажлыг гүйцэтгэжээ.

Хөндий болон түүний эргэн тойрны дүүргийн геологийн тогтоцыг судлан хар өнгийн шаварлаг занар, цагаан өнгийн гантигжсан шохойн чулууг дунд палеозойд, конгломерат-элсэн чулуу, элсэн чулуу-занар, шохойлог элсэн чулуу-занарыг дээд эрт төрмөлд хамааруулан конгломерат-элсэн чулуу, эффузивийн зузаалгийг юрийн, элсэрхэг алевролит-шавар, эффузив-шаварлаг-элсэнцэр, шаварлаг занрыг доод цэрд, элсэнцэр-шавар, эрээн өнгийн хайрга-шавар-элсэнцрийн зузаалгийг дээд цэрдийн настай хурдсанд тус тус ангилжээ.

1955 онд энэ дүүрэгт В.А.Макаров 1:1000000 масштабын геологийн зураглал, эрлийн ажлыг гүйцэтгэн эрт төрмөлийн хурдсыг пермд, дунд төрмөлийн настай хурдсыг юра, цэрдийн гэж ангилжээ. Дүүрэгт тархсан интрузив чулуулгийг пермийн өмнөх үеийнх гэж үзсэн боловч дараа дараагийн судлаач геологчид арай эртний насанд хамааруулсан байна.

1966 онд Д.Д.Сагалуев 1:500000 масштабын геологи-гидрогеологийн зураглалын ажлыг гүйцэтгэн дүүргийн геологийн тогтоцыг нарийвчлан тодотгож структурын 5 комплексийг палеозойн өмнөх, доод палеозойн, дунд палеозойн, мезо-кайнозойн гэж ангилан ялгажээ.

1964 онд В.В.Соловьев Дундговь аймгийн нутагт нүүрсний эрлийн ажил гүйцэтгэх явцдаа Хөөтийн хонхорын ордыг илрүүлэн хэсэгхэн талбайд хайгуул хийж 104124 мян.тонн

нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тооцжээ. Үүний 57346 мян.тонн нь С1, 46778 мян.тонн нь С2 зэргийнх байжээ.

3. Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажлын горим

Уурхайн- Жилийнхүчин-чадал

Техник-эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэхдээ ордын хүчин чадлыг 1 сая.тн-оор хийж гүйцэтгэсэн боловч манай компани 2023 онд үүсээд байгаа цар тахал, хилийн нэвтрүүлэх чадвар зэргээс шалтгаалан төлөвлөсөн нүүрсээ бүрэн гүйцэд олборлох боломжгүй болж байна.

Уулын ажлын горим

Ил уурхай нь уулын ажлыг жилд 5-р сарын 1-ээс 12-р сарын 31 хүртэл ажиллуулахаар төлөвлөлөө. Жилд ажиллах хоногийн тоо 215 байна.

Уулын ажлыг 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар сонголоо.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд ажиллах хоног болон, уурхайн ажиллах горимыг хүснэгт 2-т үзүүлээ.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үндсэн ажиллагаа	Хэмжих нэгж	Уурхайд
1	Хуанлийн өдөр (01.01-12.31)	Хоног	365
2	Баяр ёслолын амралт	Хоног	7
3	Цаг агаарын саатал	Хоног	10
4	Жилд ажиллах хоног	Хоног	348
5	Хоногт ажиллах ээлж	Ээлж	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12

Хүснэгт 3. Процессууд ба тоног төхөөрөмжийн ажиллагааны ажлын горим

д/д	Процессын нэр	Тоног төхөөрөмж	Гори
1	Экскаваци	Экскаватор	Хоногт 2 ээлж
2	Тээвэр	Автосамосвал	Хоногт 2 ээлж
3	Овоолго	Бульдозер, утгуурт ачигч	Хоногт 2 ээлж

4. Ашиглалтын систем

Хөөтийн нүүрсний ордыг ил уурхайн аргаар автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр олборлоно.

Ордын хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, уулын ажлын тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан дараах ухаж-ачих-тээвэрлэх тоног төхөөрөмжүүдийн хувилбаруудыг авч үзсэн байна.

Гидравлик экскаватор-автосамосвалын хослолоор ашиглах. Олборлолтын хэсгүүд рүү шилжих ажиллагаа хялбар, уурхайн зохион байгуулалтанд уян хатан байх боломжийг бүрдүүлдэг. Гидравлик экскаватор, автосамосвалын хослол нь налууболон босоо уналтай, нийлмэл давхаргатай ордод ашиглахад хамгийн тохиромжтой хувилбар байдаг бөгөөд уг хослолыг төрөл бүрийн нөхцөлтэй ордуудад түгээмэл хэрэглэдэг тул төсөлд гидравлик экскаватор-автосамосвалын хослолоор ашиглахаар төлөвлөсөн.

Доголын өндөр: Нүүрсний хаягдал, бохирдлыг бага байлгах, ухаж ачих тоног төхөөрөмжийн ажиллах нөхцөл зэргийг үндэслэн ил уурхайн ажлын доголын өндрийг $H_d = 5$ м байхаар тооцов.

Ажлын бус доголын өндөр: Уурхайн ажлын доголыг цаашид C –зэрэглэлийн нөөцийг ашиглах бөгөөд, ил уурхайн хүрээ хязгаарт C –зэрэглэлийн нөөцийг ашиглалт явуулах үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголыг ажлын 2 догол нэгтгэн үүсгэх ба өндөр нь 10 м байна.

Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг: Ил уурхайн хажуугийн өнцгийг ордын чулуулгийн физик, механик шинж чанар мөн ижил төстэй уурхайн (Багануур, Шивээ-Овоо, Цагаан Овоо) ерөнхий налууг үндэслэн тогтоосон. Ил уурхайн зохиомжлолоор ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг дунджаар $40-45^{\circ}$ байна.

Ажлын доголын хажуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн шинж чанараас хамааруулан хөрс, нүүрсний доголд $\alpha_d = 70^{\circ}$ байхаар тооцлоо.

Ажлын талбайн өргөн: Ажлын талбайн хамгийн бага өргөн 30 м, хэвийн өргөн 50 м байна. Траншей нэвтрэлтийн өргөн түүнд ажиллах техникийн аюулгүй ажилгааг тооцон 30 м-ээр төсөлөөс тусгалаа.

Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	5	
2	Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	10	C- нөөцийг ашиглалт явуулах үед 2 догол
3	Ажлын доголын хажуугийн өнцөг	град	$60-70^{\circ}$	
4	Ажлын бус доголын хажуугийн	град	$60-70^{\circ}$	Сэвсгэр хурдсанд- 50°
5	Ажлын талбайн өргөн	м	50	
6	Траншейн өргөн	м	30	
7	Траншейн налуу	%	70	
8	Доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	3	

9	Капитал траншейн өргөн	м	30	
10	Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг	град	45	Уурхайн налуу замтай хажуугийн

5. Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Хөөтийн хонхор-2 уурхайн нүүрсний блокийн дундуур шавар хөрсний нимгэн зузаан үеүд ихтэй ашиглалтын үед бохирдол хаягдал их гардаг тул шанаганы шүдэнд нэмэлт хусуур суулгаж дээрх асуудлыг зохих хэмжээнд шийдвэрлэж 2009 оноос ашиглаж МУ-ын зөвлөх инженер Ц.Нанзад, МУ-ын мэргэшсэн инженер С.Ганбат нарын “**Нүүрсний давхаргаас шавар, улууны үеийг ялгах хэрэгсэл**”-ийг санаачлан бүтээж Монгол улс ашигтай загварын гэрчилгээнд 2011-10-26 өдөр бүртгүүлж авсныг энхүү төслийн хаягдал бохирдлын тооцоонд ашиглаж байна.

1. Нүүрсний хаягдал, бохирдлын тооцоо

Уурхайн хил хязгаар доторх нүүрсний давхаргын урт 2176 м, өргөн 1480 м байна. Нүүрсний давхраасын дундах хоосон чулуулаг, шаврын үеүд бохирдохоор тооцоолов. 2023 онд нүүрсний дээд давхарга болох 2В болон 11С болон 14С блокуудад олборлолтын ажил явагдана.

Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дүн
1	Төсөлхэрэгжүүлэгчкомпани		"Биг Могул Коал энд
2	Компанийн улсын бүртгэлийнгэрчилгээнийдугаар		9011665117
3	Тусгай зөвшөөрлийндугаар		MV-020772
4	Ашигт малтмалын төрөл		Нүүрс
5	Ашиглалтын технологи		Авто тээвэртэй систем
6	Геологийн нөөц, нөөцийнзэрэглэлээр		
6.1	В зэрэглэлээр	сая.тн	4.327
6.2	С зэрэглэлээр	мян.тн	59.6
6.3	В+С зэрэглэлээр	сая.тн	4.386
7	Ил уурхайн хүрэн дэх үйлдвэрлэлийн нөөц		
7.1	Уурхай	тн	4,431,0
8	Нүүрснийхаягдал	%	1.2
9	Нүүрснийбохирдол	%	1.2
10	Орд ашиглалтын хугацаа	жи	15
11	1тн нүүрсний бүрэн өртөг	төг/тн	29,962
12	Борлуулалтын орлого (ордын нийт)	тэрбум.төг	177.3
13	Нийт хөрөнгөорүүлалт	тэрбум.төг	15.8
14	Өнөөгийнүнэ, цэнэ NPV@0%	тэрбум.төг	38,5
15	Өнөөгийнүнэ, цэнэ NPV@10%	тэрбум.төг	14,1
16	Өгөөжийндотооднорм, IRR	%	34.1
17	Хөрөнгөорүүлалтаанөхөххугацаа	жи	3,7
18	Улсын төсөвтуруулахтатвар, төлбөр (ордыннийт)	тэрбум.төг	26,5
19	Нийт ажиллагсдын тоо	хүн	145
20	Нэг ажилчины сарын дундаж цалин	мян.төг	1,448.1

2. Уулын ажлын төлөвлөгөө, уурхайн талбайг ашиглах дараалал

Хөөтийн хонхор-2 ил уурхайн нүүрсний давхраас хойноосоо урагш чиглэсэн (0-6 град) уналтай, суналын дагуу нилээд урт үргэлжилсэн давхарга тул ил уурхайн талбайг нээхдээ ерөнхий капитал 1 траншейг ашиглахаар төлөвлөсөн бөгөөд ордын уул геологи, уул-техникийн нөхцөл, нүүрсний давхраасын зузаан, уналын өнцөг зэрэг нөхцлүүд мөн дэд бүтэц, талбайн онцлог зэргээс хамааруулан уурхайн нээлтийг сонгосон.

Хөөтийн хонхор-2 ил уурхайн нээлтийн дэвсгэр зургийг хавсралт зурагт үзүүлэв. Уурхайн 2021 оны олборлолтыг үргэлжлүүлэн ашиглах ба нээсэн нүүрсийг цэвэрлэн шууд олборлох боломж бүрдсэн байгаа. Хөөтийн хонхор-2 ил уурхайн ордын нүүрсний давхарга хойноосоо урагш чиглэсэн (0-15 град) уналтай, суналын дагуу нилээд урт үргэлжилсэн давхаргатай бөгөөд ерөнхий капитал 1, түр 1 траншейг нээн ордыг ашиглаж эхэлсэн.

Хөөтийн хонхор-2 нүүрсний ордын ил уурхайн уулын ажлын төлөвлөлтийг “SURPAC” MINIX болон AUTOCAD программын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

Уурхайн цаашдын ахилтын чиг нь нүүрсний давхраасын суналын дагуу хэлбэржин тогтох бөгөөд доголын фронтын чиг ахилтад перпендикуляр байхаар байна. Уурхайн 2023 оны уулын хөрс хуулалтын коэффициентийг жигд байлгах, ажлын талбай, доголын хэлбэржилт зэргийг үндэслэн тооцоолсон болно.

3. 2023 оны уулын ажлын хөрс хуулалт болон нүүрс олборлолтын хэмжээ

Хөрс хуулалтанд DOOSAN-800 маркийн 5 м3 шанаганы багтаамжтай экскаватор, нүүрс олборлолтод HYUNDAI маркийн 3 м3 шанаганы багтаамжтай экскаватор ашиглана. Мөн зам талбай бэлтгэх, нүүрсний цэвэрлэгээ, траншей нэвтрэлтийн ажил зэрэгт HYUNDAI-2900, HYUNDAI-3000 маркийн 1.1 м3 шанаганы багтаамжтай экскаватор ашиглана.

Уурхай нь 2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулах ба нийт 1000.0 мян.тн нүүрс олборлон борлуулахаар тооцлоо.

Хүснэгт 6. 2023 оны уулын ажлын хэмжээ

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Ил уурхайн хүрэн дэх геологийн нөөц	Хөрс	м ³	3,236,722
	Нүүрс	тн	1,001,836
	Кхх	м ³ /тн	3.23
Хаягдал 4.05%		тн	40,574
Бохирддол 4.03%		тн	38,739
Үйлдвэрлэлийн нөөц	Хөрс	м ³	3,239,292
	Нүүрс	тн	1,000,000
	Кхх	м ³ /тн	3.24

4. Ухаж ачих ажил

Хөрс хуулалтанд DOOSAN-800 маркийн 5 м³ шанаганы багтаамжтай экскаватор, өнгөн хөрс хуулалт болон нүүрсний давхарга хоорондын хөрс хуулалтын ажилд HYUNDAI 520 болон DOOSAN-520 маркийн 3-3,2 м³ шанаганы багтаамжтай экскаватор, Нүүрсний таац цэвэрлэгээ болон ачилтанд HYUNDAI 2900, HYUNDAI 3000 маркийн 1,1 м³ шанаганы багтаамжтай экскаватор, хөрс сийрэгжүүлэлт болон нүүрс ачилтанд HYUNDAI 500 маркийн экскаватор ажиллахаар төлөвлөлөө.

Хүснэгт 7. Хөрс хуулалтанд ажиллах экскаваторын бүтээлийн тооцоо

№	Тэмдэглэгээ	Үзүүлэлт	Х.н	Тоон утга	Тоон утга
1		Ажиллах экскаваторын төрөл		HYUNDAI 520	HYUNDAI 500
2		Утгуурын багтаамж	м ³	3.20	2.4
3	Hmax	Ажлын доголын хамгийн их өндөр	м	8.74	8.7
4	Ao	Экскаваторын орлын өргөн	м	18.32	18.32
5	Ryt	Утгалтын түвшин дэх радиус	м	11.45	11.45
6	пор	Экскаваторын орлын тоо	тоо	1.00	1.0
7	tэм	Циклийн хугацаа	сек	26.00	26.00
8	tэр	Эргэх хугацаа	сек	6.00	6.0
9	ty	Утгах хугацаа	сек	8.00	8.0
10	tac	Асгах хугацаа	сек	6.00	6.0
11	Ky	Утгуур дүүргэлтийн итгэлцүүр	-	1.10	1.1
12	Km	Мөрөгцөгийн нөхцөл тооцох итгэлцүүр	-	0.90	0.9
13	Kэт	Экскаваторын төрлийг тооцох итгэлцүүр	-	0.92	0.9
14	Kт	Техникийн бэлэн байдлын итгэлцүүр	-	0.85	0.8
15	Kоп	Операторын ур чадварын итгэлцүүр	-	0.90	0.9
16	Kyc	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилт итгэлцүүр	-	1.30	1.3
17	Qте	Экскаваторын техникийн бүтээл 1 цаг	м ³ /цаг	237.48	178.11
18	Tэ	Ээлжинд ажиллах хугацаа	цаг	10.00	10.00
19	Kца	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.83	0.9
20	Kтх	Экскаваторыг тээврээр хангах нөхцөл тооцох	-	0.90	0.9
21	Kма	Мөргөцөг дахь ахилт шилжилтийг тооцох	-	0.85	0.8
22	Qээ	Ээлжийн бүтээл	м ³ /ээлж	1,507.86	1,226.27
23	nэ	Ээлжийн тоо		2.0	2.
24	Qэх	Хоногийн бүтээл	м ³ /хоног	3,015.71	2,452.54
25	N	Жилд ажиллах хоног	хоног	250.00	250.00
26	Nзас	Жилд хийгдэх төлөвлөгөөт засварын хугацаа	хоног	70.00	-
27	Nэк	Экскаваторын жилд ажиллах хоног		180.00	250.00
28	Qэж	Жилийн бүтээл /Техникийн/	м ³ /жил	542.83	613.13
30	-	Нэг шанаганд утгагдах чулуулгийн хэмжээ	м ³	2.71	2.0
31	-	Нэг шанаганд утгагдах чулуулгийн хэмжээ	тн	7.31	5.4
31	Va	Автосамосвалын гэвшний багтаамж	м ³	18.0	18.
32	n	Утгалтын тоо	ш	6.0	6.
33	tac	Нэг автосамосвалыг ачих хугацаа	мин	1.2	1.

34		Жилд хийх уулын ажлын хэмжээ	м3/жил	436.74	229.01
35		Уурхайн шаардлагатай экскаваторын	Ш	0.8	0.4
36		Уурхайн шаардлагатай экскаваторын бодит	Ш	1	1

5. Уурхайн тээвэр

Уурхайн хөрс болон нүүрс тээвэрлэлтийн механикжуулалтын ажлыг автосамосвалын тусламжтайгаар гүйцэтгэнэ. Хөрсийг ил уурхайн зүүн хойд талд байрлах хөрсний гадаад болон ил уурхайн хойд талд дотоод овоолгод тээвэрлэн овоолох ба хөрс тээвэрлэлтийн дундаж зай 1.4 км байна.

Ашиглалтын жил	Хөрс хуулалтын хэмжээ, м3	Нүүрс олборлолтын хэмжээ, тн	Хөрс тээвэрлэлтийн зай, км	Нүүрс тээвэрлэлтийн зай, км
2023	3239.29	1,000,000	1.4	1.4

Хүснэгт 8 Талын зай

Хүснэгт 9. Автосамосвалын бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Даац	тн	20
2	Өөрийн масс	тн	12.3
3	Тэвшний багтаамж	м ³	15.6
4	Дээд хурд	км/цаг	70
5	Хөдөлгүүрийн заасан чадал	кВт	350
6	Дугуйн томъёо		6x4
7	Оврын хэмжээ - Урт - Өргөн - Өндөр	мм	9,900 2,495 3,600
8	Эргэлтийн радиус	м	20

№	Үзүүлэлт	Тэмдэг- лэгээ	Хэмжих нэгж	Хөрс /MT86/	Нүүрс /Howo/
				Тоон утга	
1	Экскаваторын циклийн хугацаа	tm	сек	3.2	1.1
2	Автосамосвалын даац	qa	тонн	60	20
3	Автосамосвалын тэвшний эзлэхүүн	Va	м ³	23.76	14.35
4	Автосамосвалыг ачих шанаганы тоо	n	шанага	9.00	13.00
5	Чулуулгийн эзлэхүүн жин	□	тн/м ³	2.5	1.38
6	Ачилт хийх хугацаа	ta	мин	4.8	5.42
7	Тээврийн зай	L	км	1.4	1.4
8	Ачаатай үеийн дундаж хурд	Va	км/цаг	20	20
9	Ачаагүй үеийн дундаж хурд	Va	км/цаг	25	25
10	Хөдөлгөөн хийх хугацаа	tx	мин	4.9	4.9
11	Сэлгээ хийх хугацаа	tc	мин	2.00	2.00
12	Ачаа буулгах хугацаа	tб	мин	4.00	2.00
13	Ээлжийн үргэлжлэх хугацаа	Tэ	цаг	12.00	12.00
14	Рейсийн үргэлжлэх хугацаа	Tr	мин	15.70	14.32
15	Ээлжинд хийж чадах тах рейс	Nmax	рейс	45.86	50.29
16	Автосамосвалын онолын бүтээл	Qo	м ³ /тн	90.80	60.13
17	Ачааны бодит эзлэхүүн	Vб	м ³	24.37	14.35
18	Тэвшний эзлэхүүн ашиглалтын коэф	Kт	-	0.9	0.9
19	Автосамосвалын техникийн бүтээл	Qt	м ³ /ц	81.72	54.12
20	Даац ашиглалтын коэффициент	kq	-	1	1
21	Автосамосвалын бодит даац	qb	тн	60	20
22	Техникийн ээлжийн бүтээл	Qtэ	м ³ /ээлж	975.37	625.83
23	Цаг ашиглалтын коэффициент	Kца	-	0.8	0.8
24	Техникийн бэлэн байдлын коэф.	Kбб	-	0.8	0.8
25	Операторын ур чадварын коэф.	Kуч	-	0.9	0.9
26	Ашиглалтын ээлжийн бүтээл	Qaэ	м ³ /ээлж	564.86	374,06
27	Ашиглалтын хоногийн бүтээл	Qх	м ³ /хон	1,129.73	748,12
28	Ашиглалтын жилийн бүтээл	Qж	м ³ /жил	368,291.35	243,887.35
29	Шаардлагатай автосамосвалын тоо	N	ш	2.31	1.93
30	Жилд ажиллах мото цаг		мото.цаг	43,202	13,223

6. Овоолгын аж ахуй

Уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, автосамосвалаар тээвэрлэн хөрсний гадаад овоолгод хураах ба овоолгыг талбайн болон захлах хэлбэрээр бульдозерын тусламжтай гүйцэтгэсэн. Дээрх ажилд Shantui SD16 маркийн бульдозер, болон ZL 50 маркын утгуурта ачигч ажилласан.

Шимт хөрсийг 0.3 м-ийн зузаантайгаар хуулах ба ил уурхайн хойд талд 1.5 км-ийн зайтай тусгайлан зассан талбайд хураана. Шимт хөрсний чанар болон салхинд хийсэхээс сэргийлж шимт хөрсний овоолгыг ургамалжуулна. Шимт хөрсийг монгол улсын стандарт журмын дагуу хадгална.

Хүснэгт 10. 2023 онд эвдрэлд орох талбай

Шимт хөрс хуулах талбай Ил уурхай	Тоо, хэмжээ	
	м2	га
Дүн	177,559	17.76

2023 онд нийт 3,236.72 мян.м3 хөрс хуулах ба үүнээс шимт хөрс 35.51 мян.м3, тэслэгдсэн чулуулаг сийрэгжсэн байдлаар 1,262.32 мян.м3, тэслэгдээгүй чулуулаг 2,268.27 мян.м3 нийт гадаад овоолгийн эзэлхүүн 3,493.09 мян.м3 болно. Хөрсний гадаад овоолго нь нийт 53.9 га талбай эзэлнэ.

Овоолгын тээврийн зурвасын өргөн 25 м, доголын налуу 38° байна. Овоолгыг хур тунадас ихтэй зуны улиралд суулт гулсалт гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Цас мөсийг овоолгод хураахыг хориглоно. Овоолго дээрх суулт гулсалтаас сэргийлэхийн тулд суваг шуудуу татаж ажиллана. Хөрсний овоолго дээр буулгасан хөрсний 30%-ийг түрнэ.

Хүснэгт 11. SHANTUI SD16 бульдозерийн техникийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Хөдөлгүүрийн чадал	кВт	120
2	Масс	тн	17
3	Хусуурын хамах чадвар	м3	8,7
4	Хусуурын урт	м	3,93
5	Хусуурын өндөр	м	1,69
6	Ухах гүн	м	0,58
7	Хөдөлгөөний хурд, хойшоо/урагшаа	км/цаг	3/13,9
8	Шатахууны савны багтаамж	л	643
9	Бульдозерийн өргөн	м	3.032
10	Бульдозерийн урт	м	5.14

Хүснэгт 12. SHANTU SD16 бульдозерийн бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлт	Тэмдэг -лэгээ	Хэмжих нэгж	Тоонутга
1	Нэг цагийн турш овоолго дээр ачаа буулгах автосамосвалын тоо	N _{ца}	ш	12.00
2	Ажлын нэг цагт ноогдох хөрс хуулалтын хэмжээ	W _ц	м ³	451.25
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа	T	цаг	12
4	Экскаватор, автосамосвалын жилийн ажлын хоног	N	хоног	326
5	Экскаватор, автосамосвалын хоногт ажиллах ээлжийн тоо	нэ	ээлж	2
6	Уурхайн ажиллагааны жигд бусыг тооцох итгэлцүүр	K _{жб}	1,25-1,5	1.4
7	Овоолго дээр нэг зэрэг буулгалт хийх автосамосвалын тоо	N _а	ш	1
8	Овоолго дээр автосамосвал буулгалт сэлгээ хийх хугацаа	t _{б.с}	мин	2
9	Ачаа буулгах автосамосвалын сэлгээ хийхэд шаардагдах овоолгын фронтын дагуух зурвасын өргөн	l _з	м	30
10	Автосамосвалын нэг рейсэнд тээвэрлэх хөрсний эзлэхүүн	V _а	м ³	81.28
11	Үлдэц асгацын хөндлөн огтлолын талбай	S _{ас'}	м ²	2.49
12	Асгацын хөндөн огтлолын талбай	S _{ас}	м ²	8.18
13	Автосамосвалын тэвшний өргөн	B _а	м	2.98
14	Асгацын хажуугийн өнцөг		град	55
15	Овоолгын тогтвортой өнцөг		град	33
16	Овоолгын хажуугийн өнцөг		град	35
17	Асгацын өндөр	h _{ас}	м	1.32
18	Овоолго дээр асгалтын дараа үлдэх үлдцийн хувь	K _ү	%	30.5
19	Овоолгын доголын өндөр	H _о	м	10
20	Хусуурын урт	l _х	м	3.93
21	Хусуурын өндөр	h _х	м	1.69
22	Түрэлт ашиглалтын коэффициент	K _{тг}	-	1.22
23	Сэлгээ тооцох коэффициент	K _с	-	0.8
24	Хаягдлыг тооцох коэффициент	K _х	-	0.96
25	Цаг ашиглалтын коэффициент	K _{ца}	-	0.83
26	Техникийн бэлэн байдлын коэффициент	K _{бб}	-	0.7
27	Операторын ур чадварын коэффициент	K _{уч}	-	0.9
28	Түрэх призмийн хөндлөн огтлол	S _{тп}	м ²	2.04
29	Овоолгын бульдозерын цагийн бүтээл	Q _{бц}	м ³ /цаг	196.82
30	Овоолгын бульдозерын ээлжийн бүтээл	Q _{бэ}	м ³ /ээлж	2,361.83
31	Овоолго дээр бульдозероор гүйцэтгэх ээлжийн ажлын хэмжээ	V _{ац}	м ³ /ээлж	505.63
32	Шаардлагатай бульдозерын бодит тоо	N	ш	0.21(1)
33	Жилд ажиллах мото цаг		мото.цаг	5,380

6. Дэд бүтэц

1. Усны хэрэглээ

Уурхайн ажилчдын хотхоны усан хангамжийг Баянжаргалан сумын худгаас хангасан. Ил уурхайн технологийн замын усалгааны усыг “МАК” ХХК – ны зам усалгааны техникийг түрээслэх гүйцэтгэсэн. Төслийн ерөнхий төлөвлөгөөгөөр уурхайн ажилчдын хотхонг тусгай зөвшөөрлийн талбайн хойд талд буюу ажилчдын тосгон ойролцоогоор 2.1 м зайд байрлана. Хөөтийн хонхор-2 уурхайг ашиглах үед цэвэр усны дараах хоёр хэрэглэгч бий болно. Үүнд:

- ✓ Ажилчдын хотхоны усны хэрэглээ
- ✓ Ил уурхайн технологийн усалгааны хэрэглээ.

2023 онд уурхайд дунджаар 111 хүн нэгэн зэрэг ажиллах ба хотхоны усны хэрэглээг тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдсөн худгаас хангана. Хотхоны усны тооцоог дараах хүснэгтэд харуулав. Уурхайн унд ахуйн хэрэгцээнд 1 хүний нормийг 45 л/хоног-оор авч тооцсон, уурхайн зам талбайн усалгаанд 1м² талбайд 2л ус зарцуулахаар тооцлоо. Уурхайн 2023 оны усны хэрэгцээ болон зардлыг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 13. Ил уурхайн усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Усны		
		м ³ /хоног	м ³ /цаг	л/сек
1	Услах талбай	60	2.5	0.69
2	Засварын цех, тоног төхөөрөмжийн хэрэглээний ус	5	0.21	0.06
	Нийт	65	2.75	0.75

Дээрх усны хэрэглэгчийн тооцоог үндэслэн хөөтийн хонхор-2 уурхайд шаардагдах нийт усны хэрэглээг доорх хүснэгтэд үзүүллээ.


Хүснэгт 14. Ордын нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Усны зарцуулалт			Усны төлбөр сая.төг
		м ³ /хоног	Жилд ус хэрэглэх хоног	м ³ /жил	
1	Ажилчдын хотхон	2.5	150	375	0.33
2	Ил уурхай	65	180	11700	10.296
3	Нийт	67.5			10.626

Усны төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу тооцож Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэл болголоо.

2. Цахилгааны хэрэглээ

Хөөтийн хонхор-2 уурхай нь 2020 оны 10 – р сард “МАК” ХХК-ний өндөр хүчдлийн шугамд холбогдсон. Гадаад цахилгаан хангамжийн систем нь Баянжаргалан сумаас татсан 35/10 кВ-ын “МАК” ХХК-ний дэд станцаас тэжээгдэнэ. Хөөтийн хонхор-2 нүүрсний ил уурхайн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхайн тоног төхөөрөмжийн ажлын байрны гэрэлтүүлэг болон уурхайн хотхон, ил уурхайн засвар механикийн цехээс бүрдэнэ.



Зураг 2. Гадаад цахилгаан хангамжийн схем

